



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
Ц.УРТНАСАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.12.05 № 01/81 ЧАТ-НАТ/2014/01-ЖА

Зөрчил арилгуулах тухай

“Нийгмийн даатгалын сангийн 2013 оны үйл ажиллагаа, үр дүн”-д нийцлийн аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Нийгмийн даатгалын шимтгэлийн өрөнд 2013 онд “Нийслэл өргөө” ХХК-иас 252.2 сая төгрөгийн өртөг бүхий улсын комисс хүлээж аваагүй, ашиглалтад ороогүй 5 орон сууцыг хүлээж авсан нь Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2011 оны 21 дүгээр тогтоолын 2.5 дахь заалт “гэрээгээр худалдан борлуулах” журмыг зөрчсөн байна.

Дээрх 252.2 сая төгрөгийн өртөг бүхий орон сууцыг холбогдох журмын дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлж, худалдах худалдан авах гэрээг хүчин төгөлдөр болгох;

2. 2013 онд сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны 18 банкинд байршуулснаас Улаанбаатар хотын банк, Төрийн 2 банкаас хадгаламжийн хүүг гэрээний хугацаанд төлүүлж аваагүйн алданги 17.0 сая төгрөг болсон нь Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.6 дахь заалт, НДЕГ Улаанбаатар хотын банк, Төрийн банкны хооронд хийсэн Мөнгөн хөрөнгийн хадгаламжийн гэрээний 3.4, 3.6 дахь заалтыг зөрчсөн байна.

Дээрх 17,0 сая төгрөгийн хадгаламжийн хүү төлүүлэх;

3. Нийгмийн даатгалын шимтгэлийн өрөнд “Эко констракшн” ХХК-иас 274.6 сая төгрөгийн 3 подваль шилжүүлэн авсан боловч 96.1 сая төгрөгийн өртөгтэй 1 подвалыг “Тэмүүлэл-10” СӨХ нь одоог хүртэл эзэмшиж байгаа нь мөн 2011 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “гэрээгээр худалдан борлуулах” журмыг зөрчсөн байна.

Дээрх 96.1 сая төгрөгийн өртөг бүхий подвалийг журмын дагуу худалдан борлуулж, үнийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх;

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн албан шаардлагыг өгч байна.

2015 оны 1 дүгээр улиралд багтаан биелэлтийг Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

ШИНЖЭЭЧ



Л.НЯМТӨМӨР